



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 06 сарын 27 өдөр

Дугаар 291

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө залруулан бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1, 4.1.4, 4.3, 4.6, 4.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Ховд аймаг дахь Прокурорын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 7,509,000.00 (долоон сая таван зуун есөн мянга) төгрөгийн балансын үнэтэй, 501 м.кв талбай бүхий газар буюу биет бус хөрөнгө (газрын эрх)-ийг 277 м.кв талбайгаар нэмэгдүүлж, нийт 778 м.кв буюу 11,670,000.00 (арван нэгэн сая зургаан зуун далан мянга) төгрөгөөр, Нийслэлийн Баянгол дүүргийн Прокурорын газрын хөрөнгөд бүртгэлтэй, 1297 м.кв талбай бүхий газар буюу биет бус хөрөнгө (газрын эрх)-ийн нийт 34,905,640.00 (гучин дөрвөн сая есөн зуун таван мянга зургаан зуун дөх) төгрөгийн балансын үнийг 28,637,760.00 (хорин найман сая зургаан зуун гучин долоон мянга долоон зуун жар) төгрөг болгон хавсралтад заасны дагуу тус тус залруулан бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, Хэрэг эрхлэх газрын дарга С.Гансэлэм, Ховд аймгийн Прокурорын газрын Ерөнхий прокурор Д.Энхбаяр нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгийг хавсралтад заасны дагуу бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

133001438
14-r huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны 08 дугаар сарын 17-ний өдрийн
19/..... дугаар тогтоолын хавсралт

НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ ДҮҮРЭГ, ХОВД АЙМАГ ДАХЬ ПРОКУРОРЫН ГАЗРЫН
ХӨРӨНГИЙН БҮРТГЭЛД ТУСГАХ БИЕТ БУС ХӨРӨНГӨ (газрын эрх)

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, байршил	Үндсэн хөрөнгө бүртгэх байгууллагын нэр	Ашиглалтад орсон, бүртгэсэн он	Нэг бүрийн м.кв-ийн үнэ (төгрөг)	Хэмжих нэгж	Тоо хэмжээ (м.кв)	Балансын нийт үнэ (төгрөг)
1	Биет бус хөрөнгө (газрын эрх), Ховд аймаг, Жаргалант сум, 5-р баг Буянт хороо	Ховд аймаг дахь Прокурорын газар	2008/2025	15,000.00	м2	778	11,670,000.00
2	Биет бус хөрөнгө (газрын эрх), Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 4-р баг, Замчдын гудамж	Нийслэлийн Баянгол дүүргийн Прокурорын газар	2020/2025	22,080.00	м2	1297	28,637,760.00
НИЙТ ДҮН							40,307,760.00
							(дөчин сая гурван зуун долоон мянга долоон зуун жаран төгрөг)